


~~ЗӨВШӨӨРӨВ:~~
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б. БАЯРЧИМЭГ



ШҮДНИЙ ЭМЧИЙН
“ШҮДНИЙ СУВГИЙН ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Индекс S(r) 091106
Хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

П.Оюун-Энх	Нүүр ам судлалын сургуулийн Шүдний төв эмнэлгийн сувгийн эмчилгээний тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, Монголын Эндодонтын холбооны удирдах гишүүн
Б.Баярчимэг	Нүүр ам судлалын сургуулийн Шүдний төв эмнэлгийн Шүдний тулгуур эд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, дэд профессор

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Мэргэжлийн нийгэмлэг холбоодын төлөөлөл

О.Цэцэн	Нүүр ам судлалын сургуулийн багш, Анагаах ухааны магистр, Монголын Эндодонтын холбооны удирдах гишүүн
---------	---

ХЯНАСАН:

Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үндсэн мэргэшлийн сургалт хариусан ахлах мэргэжилтэн

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
01 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

ШҮДНИЙ СУВГИЙН ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛЫН ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Шүдний цоорол, түүний хүндрэл, тулгуур эдийн өвчинтэй хавсарсан зөөлцийн болон шүдний сурвалжийн оройн үрэвсэл нь хүн төрөлхтний дунд өргөн тархсан, архаг халдварт эмгэгүүд бөгөөд шүдгүйдэлд хүргэх үндсэн шалтгаануудын нэг болж байна. Сүүлийн жилүүдэд манай орны хүн амын ихээхэн хэсэг хот суурин газар шилжин амьдарч, амьдралын хэв маяг, үндэсний уламжлалт дадал заншил өөрчлөгдөн, нүүрс ус бүхий чихэрлэг хүнсний хэрэглээ ихэссэнтэй холбоотой хүн амын дунд ялангуяа бага насны хүүхдийн шүд цоорох өвчний тархалт, түүний хүндрэл жилээс жилд нэмэгдсээр байна. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад цоорлын эрсдэлийг урьдчилан тодорхойлж, нотолгоонд суурилсан эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн аргыг хэрэгжүүлснээр энэ өвчний тархалтыг бууруулж байна. Сувгийн эмчилгээ хийх явцад гарах эмчилгээний хүндрэл, зарим тохиолдолд сувгийн дахин эмчилгээ хийх, хуучин сувгийн материал авах, шүдний тойрон эдийн нөхөн төлжилтийг сэдээх эмчилгээний төлөвлөгөө боловсруулах шаардлага байгаа тул оношилгоо, эмчилгээний өндөр мэдлэгтэй, эмнэлзүйн болон харьцааны өндөр ур чадвар бүхий нарийн мэргэжлийн эмч бэлтгэх шаардлага гарч байна. Иймээс нүүр амны сувгийн эмчилгээ судлалын чиглэлээр тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, өвчлөлийн тархалтыг бууруулах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/174, 2014 оны 09 сарын 12 ны А/370, Монгол улсын Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны 09 сарын 01 ны А/337, Эрүүл Мэндийн Сайдын 2018 оны 10 сарын 19 ны А/427 тоот тушаал, журмуудыг баримтлан боловсруулав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Сургалтын зорилго: Сургалтыг олон улсын жишгийн дагуу зохион байгуулж, олон улсын түвшинд тэнцэхүйц мэдлэг, ур чадвар, хандлага бүхий шүдний сувгийн эмчилгээний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд ажиллах мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухамсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын өндөр мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инновац бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна

ДӨРӨВ. ЦОГЦ ЧАДАМЖ

Чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, мэргэжлийн тусламж үйлчилгээг бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Шүдний сувгийн эмчилгээ судлалын эмч байх
2. Мэргэжлийн байх (professional)
3. Суралцагч байх (learner)
4. Харилцагч байх (communicator)
5. Хамтрагч байх (collaborator)
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (community health advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (leader)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Хөтөлбөр нь доорх зорилтыг ханган биелүүлнэ:

Зорилт

- Шүдний сувгийн эмчилгээний мэргэжлийн эмчийн мэдвэл зохих өргөн мэдлэг олгоно
 - Шүдний зөөлцийн болон сурвалжийн оройн үрэвслийн шалтгаан, эмгэг жам мэддэг
 - Шүдний зөөлцийн болон сурвалжийн оройн үрэвслийн оношилгоо, ялгах онош хийдэг
 - Сувгийн эмийн эмчилгээ хийдэг
 - Сувгийн мэс заслын эмчилгээ хийдэг
 - Үйлчлүүлэгчтэй зөв боловсон харьцах, эмч өвчтөний итгэлцэл дээр үндэслэсэн халуун дотно харилцаа үүсгэх чадвар, хандлагыг төлөвшүүлэх
 - Нүүр амны эмчилгээний өрөөг зөв зохион байгуулах, багаар ажиллах, 4, 6 гараар ажиллах чадварыг эзэмшүүлнэ
 - Сургалтын төгсгөлд дараах ур чадварыг эзэмшинэ:
 - ✓ Оношлогооны ур чадвар
 - ✓ Эмнэлзүйн ур чадвар
 - ✓ Техникийн ур чадвар
 - ✓ Зөвлөгөө өгөх ур чадвар
1. Шүдний сувгийн эмчилгээ судлалын эмч байх
 - Тухайн эмч өөрийн ажиллаж байгаа эмнэлгийн (орон нутаг, дүүргийн эмнэлэг, төрөлжсөн, нэгдсэн, клиник) төвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан уйлдэл, ажилбарын стандарт удирдамжийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх
 - Өвчтөний хувийн нууцыг хадгалах. Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах

- Тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний нөөц бололцоог бүрэн дайчилж үйлчлүүлэгчид үзүүлэх мэргэжлийн тусламж үйлчилгээг шийдвэрлэх
 - Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, тайлан, бичиг баримтыг зохих журмын дагуу цаг тухайд нь хөтлөх
2. Мэргэжлийн байх (professional)
- Шүдний сувгийн эмчилгээ судлалын бусад салбар шинжлэх ухааны өндөр мэдлэгтэй, тухайн эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээр хувь нэмэр оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх
 - Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зов шийдвэр гаргахын төлөө ажиллах
3. Суралцагч байх (learner)
- Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд байнга хамрагдах
 - Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
 - Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах
4. Харилцагч байх (communicator)
- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
 - Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар уг хэллэг ашиглан тайлбарлах
 - Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх
5. Хамтрагч байх (collaborator)
- Тухайн орон нутгийн болон үйлчлэх хүрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах.
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (community health advocate)
- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
 - Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (leader)
- Мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт үргэлжлэх нийт хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна. Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр “Шүдний сувгийн эмчилгээ судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллага нь энэхүү сургалт явуулах үндсэн байгууллага байна.
 - Хөтөлбөрийн зарим агуулгын явуулах хангалттай орчин бүрдүүгүй тохиолдолд тойролтуудын 30 хүртэлх хувийг эрүүл мэндийн бусад байгууллагыг түшиглэн явуулж болно.
 - Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалт эрхлэх алба, тасаг боловсруулна.
 - Шүдний сувгийн эмчилгээ судлалын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээнд нэгдсэн бусад байгууллага)-ын амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн тасаг, ариутгалын тасаг, нүүр амны мэс заслын, нүүр амны согог заслын, нүүр амны гажиг заслын, нүүр амны эмчилгээний, хүүхдийн нүүр амны тасаг, шүдний тулгуур эд, шүдний сувгийн эмчилгээ, амны салстын өвчин судлалын тасаг, хурлын танхим, сургалтын танхимд сургалт явагдана.
 - Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2 Зайлшгүй таньж мэдэх, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

- Сургалтын төгсгөлд ажлын байранд ганцаараа бие даан тусламж үйлчилгээ үзүүлж чадах төвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналтан дор амбулаториор үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэх өвчтөний оношилгоо эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж туршлага хуримтлуулсан байна.

6.2.1.Өвчний шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод ТОХИОЛДОХ):

- Халуурах
- Шүд лугшиж өвдөх
- Шүд чинэрч өвдөх
- Зөөлөн эд хавдах
- Хавагнах
- Буглаа үүсэх

- Шүд цоорох
- Бие эвгүйрэх
- Дархлаа сулрах
- Буйлнаас цус гарах
- Буйл, арьсан дээр цорго үүсэх
- Халуун хүйтэнд өвдөх
- Шүдний цууралт үүсэх
- Шүдний булгарал, хагас булгарал

6.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд.

- K02 Шүд цоорох [кариес]
- K02.0 Шүдний паалангийн цоорол Цагаан толбон гэмтэц [анхдагч кариес]
- K02.1 Тугалмайн цоорол
- K02.2 Ясжмагийн цоорол
- K02.3 Шүдний зогсонги цоорол
- K02.4 Одонтоклази Хүүхдийн меланоденти Меланодонтоклази
- K02.8 Шүдний бусад цоорол
- K02.9 Шүдний цоорол, тодорхойгүй
- K03 Шүдний хатуу эдийн бусад өвчин Орхих нь: бруксизм (F45.8) шүд цоорох (K02.-) шүд хавирах ӨЗГ (F45.8)
- K03.0 Шүд хэт элэгдэх Элэгдэх: • түшилцэх гадаргуу • хорших гадаргуу
- K03.1 Шүд зүлгэгдэх Зүлгэгдэх: • шүдний ооноос • зуршлаас • ажил мэргэшлээс шүд • зан үйлээс • уламжлалаас Шаантган согор ӨЗГ
- K03.2 Шүдний шалбархай Шүд шалбарах: • ӨЗГ • дараах зүйлээс улбаалсан: - хоол унднаас - эмийн бэлдмэлээс - байнга бөөлжсөнөөс • идиопат • мэргэжлийн 437 K03.3 Шүд эмгэгээр шимэгдэх Шүдний зөөлцийн гранулом Шүд шимэгдэх (гаднах) K03.4 Хиперценментоз [шохойжсон ясжмаг] Ясжмагийн хиперплази
- K03.5 Шүд барьцалдах
- K03.6 Шүдний хөгц [өнгөр] Шүдний чулуу: • буйлны доорх • буйлны дээрх Шүдний хөгц: • зажилдаг өвсний • хар • ногоон • цагаан • улбар шар • тамхины Шүд будагдах: • ӨЗГ • шалтгаан тодорхойгүй ӨЗГ
- K03.7 Шүдэлсний дараа шүдний хатуу эдийн өнгө хувирах Орхих нь: шүдний хаг [өнгөр] (K03.6)
- K03.8 Шүдний хатуу эдийн бусад тодорхой өвчин Цацраг идэвхт туяагаар шарагдсан паалан Мэдрэг тугалмай Хэрэв цацраг идэвхт туяаны шалтгаантай бол цацрагийн төрлийг тодотгохыг хүсвэл гадны шалтгааны нэмэлт код (Бүлэг XX) ашиглана.
- K03.9 Шүдний хатуу эдийн өвчин, тодорхойгүй
- K04 Шүдний зөөлц ба сурвалжийн орой тойрны эдийн өвчин
- K04.0 Пульпит Зөөлцийн: • буглаа • ур Пульпит: • цочмог • архаг (хиперпластик) (шархлаат) • идээт
- K04.1 Зөөлцийн үхжил Зөөлцийн үхшил БҮЛЭГ XI. ХООЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООНЫ ӨВЧИН 438 ӨВЧНИЙ ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ
- K04.2 Зөөлцийн дегенераци Дентикл Зөөлцийн: • шохойжилт • чулуу

- K04.3 Зөөлцөд хатуу эд хэвийн бусаар үүсч хөгжих Хоёрдогч буюу жигд бус тугалмай үүсэх
- K04.4 Зөөлцийн гаралтай сурвалжийн орой хэсгийн цочмог периодонтит Сурвалжийн орой хэсгийн цочмог периодонтит ӨЗГ
- K04.5 Сурвалжийн орой хэсгийн архаг периодонтит Сурвалжийн орой хэсгийн буюу орой тойрны гранулом Сурвалжийн орой хэсгийн периодонтит ӨЗГ
- K04.6 Сурвалжийн орой тойрны хөндийт буглаа Шүдний хөндийт буглаа Дентоальвеоляр
- K04.7 Сурвалжийн орой тойрны хөндийгүй буглаа Шүдний Дентоальвеоляр буглаа ӨЗГ Сурвалжийн орой орчмын
- K04.8 Сурвалжийн уйланхай Уйланхай: • сурвалжийн оройн (шүд тойрны) • сурвалжийн орой тойрны • үлдэгдэл сурвалжийн Орхих нь: шүд тойрны хажуугийн уйланхай (K09.0) K04.9 Зөөлц ба сурвалжийн орой тойрны эдийн бусад ба тодорхойгүй өвчин

6.2.3. Гардан үйлийн жагсаалт

- Шүдний цөгц сэргээх Restoration of tooth by filling
- Инлей Restoration of tooth by inlay
- Бусад цөгц сэргээх Other dental restoration
- Шүд оромд суулгах Implantation of tooth
- Сувгийн эмчилгээ Root canal, not otherwise specified
- Сувгийн эмчилгээ, уусмалаар халдваргүйжүүлэх Root canal therapy with irrigation
- Сувгийн эмчилгээ, орой тайрах Root canal therapy with apicoectomy
- Сурвалжийн орой тайрах Apicoectomy
- Зөөлөн, хатуу эдийн зүслэг Incision of gum or alveolar bone
 - Бусад шинжилгээний аргууд Other diagnostic procedures on teeth, gums, and alveoli
 - Оёдол тавих Suture of laceration of gum

6.3 Онолын мэдлэгийг сайжруулах

Хэлэлцүүлэг/ Journal review (1 сард 5-аас дээш өгүүлэл) • Резидент нь удирдагч багштай хамтран сургалтын болон шинжлэх ухааны өгүүллийг сонгон авч уншиж бэлтгээд, хэлэлцүүлнэ.

Резидент нь еерийн сонгож авсан өгүүллийг багш ба бусад резидент эмч

нарт 15 минутын хугацаанд танилцуулан тайлбарлаж, хэлэлцуулна. • Өгүүлэл нь суулийн 3 жилийн хугацаанд хэвлэгдсэн байхыг шаардана.

Номын хэлэлцүүлэг/ Book review (Сард 2 удаа) Нэгдүгээр дамжааны резидент эмч

Резидент нь ном зүйд заасан номын хэсгийг хуваарилж авсан булгийг уншиж хэлэлцүүлэгт бэлтгэж ирнэ. Резидент нь 20-30 минутын хугацаанд өөрийн хуваарилж авсан булгийг багш ба бусад резидент эмч нарт тайлбарлан танилцуулж, хэлэлцүүлнэ.

ажилбарт нь оролцсон өвчтөний амбулатори болон тасагт байсан бүтэн түүхийг бэлтгэнэ.

- Чухал бөгөөд зонхилон тохиолддог өвчний түүхийг шаардана.
- Бүтэн түүхийг багтаана: Гол зовиур, өвчний туух, бодит үзлэг, лабораторийн шинжилгээ, урьдчилсан оношийн таамаг, эмчилгээ, эмчилгээний үр дүн, тавиланг танилцуулахын зэрэгцээ тухайн өвчний талаарх онолын мэдээллийг хүргэнэ. Бэлтгэсэн түүхийг 15 минутийн хугацаанд бусад резидент эмч нарт танилцуулна. Профессорийн удирдлагад тухайн тохиолдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ

Загвар 1

Ажлын байрны сургалт

№	Сургалтын хэлбэр	Үргэлжлэх хугацаа	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч хамтрагч
1	Тасагт шинэ хүний үзлэг	7 хоногт 4 удаа	НАСС тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
2	Сургалтын тойрон үзлэг	7 хоногт 4 удаа	НАСС тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
3	Гардан хийх үйлдэл	7 хоногт 4 удаа	НАСС тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
4	Мэс засалд оролцох	7 хоногт 1-2 удаа	НАСС тасаг	өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 2

Танхимын сургалт

№	Аргачлал	Хугацаа	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Хамтрагч
1	Бие даалт	Тохиромжтой цагт	Тохиромжтой цагт	Номын сан, интернет	Эмнэл зүйн сургагч багш
2	Лекц	7 хоногт 1 удаа	НАСС	танилцуулга	Эмнэл зүйн сургагч багш
3	Журнал клуб	Сард 1 удаа	НАСС	сэтгүүл	Эмнэл зүйн сургагч багш
4	Симуляци	14 хоногт 1 удаа	НАСС фантомны өрөө	Фантомны өрөө	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Перэв	Баасан
8-12.30	Үзлэг	Үзлэг	Үзлэг	Мэс засал	Сургалт
13.30-17.00	Үзлэг	Үзлэг	Үзлэг	Сургалт	Үзлэг

Тойролтын хуваарь

1	Тойролт 1 Ариутгал	2 долоо хохог
2	Тойролт-2 Дүрс оношлогоо	2
3	Тойролт-3 Нүүр амны мэс засал	2
4	Тойролт-4 Нүүр амны согог засал	2
5	Тойролт-5 Цоорол	6
6	Тойролт-6 Шүдний тулгуур эд судлал	8
7	Тойролт-7 Сувгийн эмчилгээ-1	22
8	Тойролт-8 Сувгийн эмчилгээ-2	44
Бүгд		88

Эмнэл зүйн тойролт - 1. Ариутгал

- Ариутгалын өрөөний зохион байгуулалт
- Ариутгалд хэрэглэх уусмал
- Ариутгалын төрөл

Багажны ангилал, халдваргүйжүүлэлт, ариутгал, хадгалах арга барил

Эмнэл зүйн тойролт - 2. Дүрс оношлогоо

- Рентген цацрагийн тухай үндсэн ойлголт, рентген хоолой цацрагийн хамгаалалт

- Шүд эрүү нүүрний дүрс оношлогооны тасгийн зохион байгуулалт, онцлог
- Шүд эрүү нүүрний дүрс оношлогооны аргууд
- Нэг шүдний рентген зураг (Apical), хэвийн анатом
- Bite-wing, хэвийн анатом
- Панорам зураг, хэвийн анатом
- Шүдний цоорлын үед рентгенд илрэх өөрчлөлт
- Шүдний сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийн үед рентгенд илрэх шинж
- Шүдний тулгуур эдийн үрэвслийн үед рентгенд илрэх өөрчлөлтүүд
- Шүд түүшингийн гэмтлийн рентген оношлогоо
- Шүд эрүү нүүрний эрхтнүүдийн эрүүл болон эмгэг өөрчлөлтүүдийг дүрс оношлогооны аргаар шинжлэх, нэг шүдний рентген зураг авах, эмгэг өөрчлөлтийн үед шинжилгээнд илрэх эмгэг шинжүүдийг илрүүлж оношлох, ялган оношлох

Эмнэл зүйн тойролт-3. Нүүр амны мэс засал

- Нүүр амны мэс заслын суурь мэдлэг
- Нүүр амны мэс засалд хэрэглэгддэг багаж материалууд
- Нүүр амны мэс засалд өргөн хэрэглэгддэг мэдээ алдуулалтууд, заалт, сонголт
- Мэдээгүйжүүлэлт хийхийн өмнө эмжүүлэлт, хэрэглэх заалт, сонголт
- Шүд авах мэс ажилбараас улбаатай хэсэг газрын хүндрэлүүд, эмнэл зүйн шинж тэмдгүүд, рентген зургаар оношлох, анхны тусламж үзүүлэх
- НАМЗ-ын өвчтөний шархыг цэвэрлэх ерөнхий зарчмууд, арга техник, боолтын төрлүүд
- Нүүр амны үрэвслүүдийн эмгэг жам, ангилал, эмнэл зүй
- Рентген зурагт гарах онцлог шинж тэмдгүүд
- Гурамсан мэдрэлийн симптоматик өвдөлт шалтгаан, эмнэл зүй, анхны тусламж үзүүлэх
- Эрүүний үений үйл хямралын өвдөлтийн хам шинж шалтгаан, эмнэл зүй, анхны тусламж үзүүлэх
- Анафилаксийн шокийн эмгэг жам, эмнэл зүй, авах арга хэмжээ
- Нүүр амны мэс заслын өвчтөнд хэсгийн мэдээ алдуулалт хийх
- Оёдол тавих, авах
- Шүд авах ажилбараас үүдэлтэй хүндрэлүүдийг оношлох, саатсан шүдний байрлалыг тодорхойлох
- Нүүр амны идээт үрэвслүүдийг оношлох, анхны тусламж үзүүлэх
- Гурамсан мэдрэлийн симптоматик өвдөлтийг оношлох, анхны тусламж үзүүлэх
- Анафилаксийн шокийн үед анхны тусламж үзүүлэх
- Эрүүний үеийн үйл хямралын хам шинжийг оношлох, анхны тусламж үзүүлэх

Эмнэлзүйн тойролт-4. Нүүр амны согог засал

- НАСГЗаслын клиникийн болон урлангийн зохион байгуулалт, эмч болон шүдний техникчийн хэрэглэх багаж, тоног төхөөрөмж
- Үүдэх ба араа бүлэг шүдний бүтэц үйл зүйн онцлог
- Шүдний цөгцний согогийн согог, ангилал, шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, согог заслын эмчилгээ

- Шүдний цөгцний бага болон дунд хэмжээний согогийг инлей болон онлейгээр сэргээх, шүдний хөндийг засах, гарч болох алдаа, түүнийг сэргийлэх
- Бүрээс, төрөл, хэрэглэх заалт, шүдийг засч бэлдэх, клиник, лаборатори ажилбар
- Голонцортой шүдэлбэр, төрөл, хэрэглэх заалт, клиник, лаборатори ажилбар, гарч болох алдаа, түүнийг сэргийлэх
- Шүдний эгнээний согогийг гүүрэлсэн шүдэлбэрээр сэргээх
- Загварлах, хэвлэх, шахах, цутгах ерөнхий аргыг эзэмших
- Үүдэн ба араа бүлэг шүдний цөгцийг геометрийн аргаар дүрслэх
- Үүдэн ба араа бүлэг шүдний цөгцийг лавайгаар сийлэх
- Шүдийг урлахад хэрэглэгдэх багар, тоног төхөөрөмжтэй танилцаж, зөв барьж сурах, ашиглах
- Шүдний цөгцний согогийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Өвчтөнд нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх

Эмнэлзүйн тойролт-5. Шүдний цоорол

Шүдний паалангийн бүтэц, үүрэг

- Шүдний тугалмайн бүтэц, үүрэг
- Шүдний ясжмаг эдийн бүтэц, үүрэг
- Шүд цоорох өвчний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд
- Шүд цоорох өвчний эмгэг жам
- Шүд цоорох өвчний патогистологи
- Шүд цоорох өвчний ангилал, эмнэлзүй
- Шүд цоорох өвчнийг оношлон илрүүлэх аргууд
- Цоорлын хөндийг хэлбэржүүлэх арга техник
- Цоорлын хөндийг ломбодох арга техник
- Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх болон өвчлөлийг тооцох аргууд
- Шүд цоорох өвчнийг оношлон, эмчилгээний аргыг зөв сонгох
- Өвчлөл тооцох эмнэлзүйн болон лабораторийн аргуудыг хэрэглэж сурах
- Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх аргуудыг эзэмшиж, нийгэм хамт
- Олны дунд урьдчилан сэргийлэлтийг хийж чаддаг болох
- Шүд цоорох өвчний үе шат, ломбодох материалын онцлогоос хамааран эмчилж сурах

Эмнэлзүйн тойролт-6. Шүдний тулгуур эд судлал

- Шүдний тулгуур эдийн бүтэц, үйл ажиллагаа
- ШТЭ-ийн өвчний шалтгаан
- ШТЭ-ийн өвчний эмгэг жам
- Шүдний тулгуур эдийн өвчний тархвар судлал
- Шүдний тулгуур эдийн өвчний урьдчилан сэргийлэлт
- Шүдний тулгуур эдийн өвчтөн шинжлэх, өвчний тавилан
- Шүдний тулгуур эдийн өвчний шалтгааныг арилгах
- Шүдний чулууны бүтэц, найрлага
- Буйлны үрэвслийн ангилал, буйлны үрэвслийн эмнэлзүй, ялгах онош, эмчилгээ
- Шүдний тулгуур эдийн үрэвслийн ангилал, цочмог явцтай шүдний тулгуур эдийн үрэвслийн эмнэлзүй, оношлогоо, ялгах онош

- Шүдний тулгуур эдийн архаг үрэвслийн эмнэлзүй, оношлогоо, ялгах онош
- Шүдний чулуу авах арга
- Шүдний тулгуур эдийн өвчтөн хяналтанд авах
- Шүдний тулгуур эдийн өвчтөнд яаралтай тусламж үзүүлэх
- Буйл шүдний эмгэг хөндийг тодорхойлох
- Цус гаралтын зэрэг тодорхойлох
- Шүдний хөдөлгөөн тодорхойлох
- Түүшин ясны шимэгдлийг рентген зургаар тодорхойлох
- Шүдний чулууг чулууны гар багажаар авах
- Шүдний чулууг ультрасоникийн багажаар авах
- Буйлны үрэвслийг ялгаж оношлох
- Шүдний тулгуур эдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх аргуудыг эзэмших
- Шүдний тулгуур эдийн өвчтөнд яаралтай тусламж үзүүлэх

Эмнэлзүйн тойролт-7. Сувгийн эмчилгээ-1

- Шүдний зөөлцийн болон сурвалжийн оройн эдийн бүтэц
- Бүх шүдний сурвалжийн сувгийн онцлог, шүдний хөндийн байршил зүйн анатомийн онцлог
- Эндодонтын микробиолог
- Өвдөлт, өвдөлтийн төрөл, оношилгоо, ялган оношилгоо, мэдээ алдуулалт
- Зөөлцийн болон СОТЭ үрэвслийн эмгэг жам, зөөлцөд гарах эмгэг өөрчлөлт
- Шүдний зөөлцийн үрэвсэлтэй өвчтөнг шинжлэх, оношлох, эмчилгээ төлөвлөх
- Зөөлцийн болон сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийг ялган оношлох, сувгийн эмийн эмчилгээ хийх заалтууд
- Сувгийн эмчилгээнд хэрэглэгдэх багаж, эм материал, тэдгээрийн хэрэглээ
- Сувгийн уртыг хэмжих аргууд, хэрэглэгдэх багаж
- Суваг өргөсгөх аргууд: алхам арагш, алхам доошоо
- Суваг ломбодох аргуудыг мэдэх
- Мэс заслын аргаар эмчлэх заалтууд, эсрэг заалтууд
- Сувгийн эмчилгээний тавиланг тооцох
- Шүдний хөндийг нээж өргөсгөх
- Сувгийн уртыг хэмжиж сурах
- Суваг өргөсгөх алхам арагш аргуудыг эзэмших
- Сувгийг латерал кондесацийн аргаар ломбодох
- Зөөлцийн болон сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийг ялган оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Сувгийн эмчилгээний тавиланг тооцох
- 1 болон олон сурвалжтай шүдний зөөлцийн үрэвслийг цогцоор нь эмчлэх
- Сувгийн эмчилгээний хүндрэлийг эмчлэх

Эмнэлзүйн тойролт-8 Сувгийн эмчилгээ-2

- Сувгийн эмгэг дотоод болон гадаад шимэгдэлтийн шалтгаан, эмчилгээ, эмчилгээний тавиланг мэдэх
- Сурвалжийн орой бүрэн хэлбэржээгүй шүдний сувгийн эмчилгээний онцлог, эмчилгээний төрлүүд

- Шүдний гэмтлийн ангилал, оношилгоо, эмчилгээ
- Суваг өргөсгөх алхам доошоо аргыг эзэмших
- Сувгийн микроскоп ашиглан уян багажаар суваг өргөсөх
- Сувгийг латераль болон бусад аргуудаар ломбодох
- Сувгийн дахин эмчилгээ
- Шүд цайруулах эмчилгээ
- Хэлбэржээгүй шүдний эмчилгээ
- Шүдний гэмтлийн үед авах арга хэмжээ
- Шүдний сувгийн мэс заслын эмчилгээ
- Шүдний апексификаци, апексогенезын эмчилгээ хийх
- Шүдний эмгэг шимэгдлийн эмчилгээ
- Уян багажаар ажиллах, сувгийн микроскоп ашиглах
- Сувгийн дахин эмчилгээ хийх
- Шүдний цайруулалт хийх
- Гэмтлийн үед эмчилгээ хийх

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

7.1 Сургалт эрхлэх байгууллага нь ажлын байрны сургалтыг удирдан явуулах эмнэл зүйн сургагч багш нарыг томилон хуваарилна. Сургалтын явц, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хяналт тавих сургалт харилцагч (mentor)-ыг сургалт эрхлэх байгууллага томилон ажиллуулна. Сургалт хариуцагч нь сар бүр 1 удаа тогтмол уулзалт зохион байгуулж суралцагч эмч нартай мэдээлэл солилцож үнэлгээтэй танилцана.

7.2 Тойролт бүрд суралцагч эмчийг сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдэд илгээж тойролтын хугацаанд хэрэгжүүлэх зорилтыг танилцуулна. Тойролт дуусахад тойролт удирдсан багштай ярилцлага хийж сургалтын үнэлгээ, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга нь сургалтын явцын үнэлгээ, төгсөлтийн шалгалт гэсэн хоёр хэлбэрээр хийгдэнэ.

Шүдний сувгийн эмчилгээ судлал сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд үндсэн мэргэшлийн үнэмлэх олгоно.

Явцын үнэлгээ ажлын байранд суурилсан үнэлгээ нь дараах аргуудаар үнэлнэ.

Явцын үнэлгээ нь нийт үнэлгээний 80 хувиас доошгүй хувийг эзэлнэ.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace-based Assesment) 360 хэмийн үнэлгээ (360 degree Assesment):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх манлайлагч байх чадамжийг үнэлэхэд хэрэглэнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

Mini-CEX /Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх 25 шинж тэмдгүүдээс 5-аас доошгүй үйлдэл бүрд 3-аас доошгүй удаа нийт 15-аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct observation of procedural skills, DOPS)

Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 20 үйлдлээс 15-аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэлзүйн удирдагч

багш нотолсон үнэлгээ. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өнгө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment)

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэл зүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ.

Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-CEX, DOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

Шийдвэр гаргах шалгуур нь

Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу ирц, сургалтын ирц хангалтгүй бол тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

Сургалт эрхлэгч байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, Шүдний тулгуур эд сувгийн эмчилгээний тасгийн эрхлэгч, багш нар, сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.

Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага доор ажиллана.

Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.

Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.

Хөтөлбөр нь хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцана.

Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл Мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Хавсралт 1

360 хэмийн үнэлгээний хуудас

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэлзүйн сургагч багш Сувилагч Бусад _____

☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Үнэлэх боломжгүй	Ховор(<19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд (>80%)

Өвчтөн гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Шүдний сувгийн эмчилгээний эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн журнал клуб, эмнэл зүйн хэлэлцүүлэгт идэвхитэй оролцдог	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Орон нутгийн болон бусад эмнэлгийн мэргэжил нэгт эмч нартай хамтран ажилладаг, сурсан мэдлэгээ хуваалцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх бусад эмч, сувилагч, мэргэжилтэнтэй, хамтран ажилладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр бол найдваргүй” гэн нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй”

Өөрөөсөө асуу: **Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?**

Явцын Mini-CEX үнэлгээний хуудас

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр: _____
нэр _____

Үнэлэгчийн

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐Клиник
☐Тасаг ☐ЯТТ ☐Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐эр ☐эм

Өвчтөний зовиур: ☐ Халуурах ☐ Толгой өвдөх ☐ Шүд өвдөх ☐ Шүд цоорох ☐ Шүд халуун хүйтэн зүйл мэдрэх ☐ Шүд хөдөлгөөнтэй болох ☐ Шүдний гэмтэл ☐ Шүдний өнгө өөрчлөгдөх ☐ Залгихад хүндрэлтэй болох ☐ Зажлахад өвдөлтэй зовууртай болох ☐ Тунгалгийн булчирхай цочих ☐ Шүд орчим хавдах ☐ Арьс улайх, идээт цорго үүсэх ☐ Ам ангайлт хязгаарлагдах ☐ Буйлнаас цус гарах ☐ Буйлан дээр идээт цорго үүсэх ☐ Эрүүний өвдөлт ☐ Хиймэл шүд хийлгэх зорилгоор ☐ Эрүүний мултрал ☐ Гажиг заслын хийлгэх зорилгоор ☐ Өмнөх эмчилгээ үр дүнгүй болсон Бусад ☐ _____

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа хэлнэ үү.
Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: ☐

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношлогоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Үнэлэгчийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын үсэг: _____

Хангалттай гэж тодорхойлоход хэрэгэлэгдэх үзүүлэлт

Өвчтөний түүх авах	- Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. - Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг - Өвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	- Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. - Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Эмнэлзүйн менежмент	- Зөв онош тавьдаг. - Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг - Тохирсон эмчилгээ эхлүүлдэг. - Бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч үзлэг эмчилгээг хэлэлцэж, шаардлагатай бол тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлж, хяналт тавьдаг.

Харилцааны ур чадвар	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	• Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. •

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Сургагч багшийн нэр: _____ Он, сар, өдөр _____ / _____ /

Суралцагч эмчийн нэр: _____ ♦ R1 ♦ R2

Үнэлгээ хийгдсэн тасаг: ♦ Амбулатори ♦ МСТасаг ♦ Оношилгооны хэсэг ♦ ЯТТ
♦ Бусад _____

Тухайн жилийн үнэлгээний дугаар: ♦ 1 ♦ 2 ♦ 3 ♦ 4 _____

Өвчтөн: _____ нас _____ хүйс ♦ Эр ♦ Эм Регистрийн
дугаар _____

Үнэлгээний төрөл: ♦ Анхан ♦ Давтан ♦ Төлөвлөгөөт ♦ Яаралтай ♦
Хойшлуулашгүй

Гардан үйлдлийн зэрэг: ♦ Хөнгөн ♦ Дунд ♦ Хүнд

Үнэлгээний зорилго: ♦ Судалгаа ♦ Оношилгоо ♦ Эмчилгээ ♦ Бусад

Гардан үйлдэл: ♦ Карт бичих ♦ Өвчтөн үзэж оношлох ♦ Рентген зургаар
оношлох ♦ Цоорлын үе шатаас хамааран эмчилгээ хийх ♦ Зөөлцийн, сурвалжийг
оройн үрэвслийг оношлох, ялган оношлох ♦ Зөөлцийн үрэвслийг биологийн аргаар
эмчлэх ♦ Мэдээ алдуулалтын дор зөөлцийг тайрах ♦ Мэдээ алдуулалтын дор
зөөлцийг бүрэн авах ♦ Шүдний сувгийн уртыг тодорхойлох ♦ Гар болон уян эргэлтэт
багажаар шүдний сувгийг өргөсгөх ♦ Шүдний сувгийг угаах, хуурайшуулах ♦ Шүдний
сувагт эмийн бэлдмэл хийх ♦ Шүдний сувгийг ломбодох ♦ Хэлбэржээгүй шүд эмчлэх
♦ Сүүн шүдний сувгийн эмчилгээ хийх ♦ Гэмтлийн үед сувгийн эмчилгээ
хийх ♦ Биоматериал, МТА тавих ♦ Мэс заслын эмчилгээтэй хавсарсан эмчилгээ
хийх ♦ Хүндэрсэн, тахир эсвэл нарийссан сувгийн эмчилгээ хийх ♦ Сплит тавих ♦
Сувагт метал болон фибер голонцор тавих ♦ Сувгийн дахин эмчилгээ ♦ Хугарсан
багаж авах ♦ Сувгийн эмчилгээнд микроскоп хэрэглэх ♦ Зөвлөгөө өгөх ♦ Сувгийн
эмчилгээний мэс ажилбарыг хийх
♦ Бусад _____

Өнөөг хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.											
Үнэлгээ хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: X											
№	Шалгуур	Хангалтгүй			Сайжруулах			Хангалттай			Үнэлгээ шаардлагагүй
		1	2	3	4	5	6	7	8	9	
1	Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт,										

	анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэддэг										
2	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарлада г /өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг										
3	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлдэг										
4	Өвчтөний аюулгүй байдлыг хангадаг										
5	Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйж үүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг										
6	Гардан үйлдлийг арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэдэг										
7	Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлг ож, шаардлагата й үед тусламж дууддаг										

8	Үйлдлийн дараахь менежментийг зохистой хангадаг										
9	Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага										
10	Үйлдлийн эмх цэгцгийг хангадаг										
11	Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд хөтөлдөг										
13	Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар										

Зөвлөмж:

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд:

Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө:

Суралцагч эмчид өгөх эцсийн санал (нэгийг сонгох):

- ◆ Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, чадвар хангалтгүй
- ◆ Сургагч багшийн хяналтанд үйлдлийг хийх /хянах түвшинг сургагч багш шийдвэрлэнэ/
- ◆ Суралцагч эмч үйлдлийг бие даан хийх боломжтой
- ◆ Суралцагч эмч энэхүү үйлдлийг бусдад заах/бусдыг хянах боломжтой

Суралцагч эмчид өгөх **БУСАД** санал:

PS үнэлгээ хийсэн хугацаа: ____ /мин/. Зөвлөгөө өгсөн хугацаа ____ /мин/

PS үнэлгээ хийсэн **БАГШИЙН** сэтгэл ханамж:

за 1 2 3 4 5 6 7 8 9 Их

PS -р үнэлүүлсэн **СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН** сэтгэл ханамж:

за 1 2 3 4 5 6 7 8 9 Их

гшийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Санамж:

САНАМЖ: “Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэдэх	Сургагч багшид үйлдлийн заалт, эсрэг заалт, холбогдох морфологи анатомийн бүтэц, үйлдлийн үе шат, үйлдлийг гүйцэтгэх аргачлал, хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн заалт, эсрэг заалт, гаж нөлөө, болзошгүй эрсдэл, хүндрэлийн үеийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй, бүрэн тайлбарлаж чаддаг.
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл /зөвшөөрлийн хуудас авах	- Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид үйлдлийн талаар бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй, ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглан зохих тайлбарыг өгдөг. - Өвчтөн үйлдлээс айсан, сэтгэл нь тогтворгүй, түгшсэн тохиолдолд зовнилыг ойлгож, хуваалцаж, хүндэтгэлтэй, тэвчээртэй ханддаг, сонирхсон асуултанд оновчтой хариулдаг. - Зөвшөөрлийн хуудас бөглөхөөс өмнө өвчтөн нь гардан үйлдлийн талаар зохих ойлголттой байгаа талаар нягталдаг. - Өвчтөнд итгэл, үнэмшил төрүүлдэг. - Өвчтөнөөс шаардлагатай ажилбарт зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг.
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлэх	- Гардан үйлдлийг гүйцэтгэх төлөвлөгөөтэй. - Өвчтөний сэтгэл санаа, тайван байдлыг хангадаг. - Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэдэг. - Ажилбарын өмнөх хяналтын хуудас бөглөдөг, ажилбарын явц болон ажилбарын дараахь хяналтын хуудас, бичиг баримтыг бэлтгэдэг. - Гардан үйлдэлд шаардлагатай хувцас, өмсгөлийг бэлтгэдэг. - Үйлдлийг гүйцэтгэхэд найрсаг, ээлтэй, дулаан, байгалийн гэрэлтэй, цэвэр орчин бүрдүүлдэг.
Өвчтөний аюулгүй байдлыг хангах	- Гардан үйлдэл хийгдэх өвчтөний овог, нэр, регистрийн дугаар болон бусад аргуудаар танин тодруулдаг. - Үйлдлийг гүйцэтгэхэд хэрэглэх/хэрэглэж болзошгүй тайвшруулах, мэдээ алдуулах эм, тарианы нэр, тун, хэрэглэх арга зэрэг чанар, аюулгүй байдлыг хангадаг. - Үйлдлийг гүйцэтгэхэд зөв зүү, тариурыг сонгож нягталдаг, чанар, аюулгүй байдлыг хангадаг.
Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэх	- Ариун бээлийг зөв задалж өмсөж, тайлдаг. - Ариун салфетка, ариун хөвөн бөмбөлөг, нэг удаагийн зүү, тариуртай зөв харьцдаг. - Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай халдваргүйжүүлэх уусмалыг зөв ашигладаг. - Үйлдлийн талбайг зөв ариутгадаг.

	• Хурц үзүүртэй зүү, эмнэлгийн хэрэгслийг зөв ашиглаж устгадаг.
Гардан үйлдлийн арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэх	• Гардан үйлдлийн стандарт, протоколыг чанд мөрддөг. • Гардан үйлдлийг өөртөө итгэлтэй, чадварлаг гүйцэтгэдэг. • Зааварчилгааг тод, чанга дуугаар, ойлгомжтой өгдөг. • Зүү, тариур, тоног төхөөрөмжийг чадамгай ашигладаг. • Эрсдлээс сэргийлдэг.
Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед тусламж дуудах	• Үйлдэл амжилтгүй байгааг өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сандарч тэвдэлгүй, зөв зохистой ойлгуулж мэдээлдэг. • Үйлдэл амжилтгүй гүйцэтгэсэнээ хүлээн зөвшөөрдөг. • Өвчтөн болон ажилчидтай тайван, зохистой харьцдаг. • Гардан үйлдлийг илүү сайн гүйцэтгэхэд бусдын тусламжийг хүсэж чаддаг. • Цаашид илүү амжилттай суралцах шаардлагатайг ухамсарладаг.
Үйлдлийн дараахь менежментыг зохистой хангах	• Суралцагч эмч нь гүйцэтгэсэн гардан үйлдэлд бодит үнэлгээ дүгнэлтийг өгч чаддаг. • Үйлдлийн дараахь эмчилгээ, асаргаа сувилгаа, халдвар хяналтын зөвлөмжийг өвчтөн болон эмнэлгийн ажилчдад амаар болон бичгээр зөв өгдөг.
Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог, зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг, эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг. • Эмнэлгийн ажилчидтай хүндэтгэлтэй, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж харьцдаг. • Хувь хүний нууцыг чанд сахидаг.
Үйлдлийн эмх цэгцгийг хангах	• Гардан үйлдлийн бүх үе шат нь тайван, эмх цэгцтэй, дэс дараатай гүйцэтгэдэг
Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд нь хөтлөх	• Гардан үйлдлийг зохих журам, зааврын дагуу баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтын огноо, цаг, үг, өгүүлбэрийг тодорхой, гаргацтай бичдэг. • Гардан үйлдэл гүйцэтгэсэн суралцагч эмч нь нэр, гарын үсгээ тодорхой, гаргац сайтай баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтыг сургагч багшаар баталгаажуулдаг.
Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар	• Өвчтөний аюулгүй байдлыг үйлдлийн бүх үе шатанд тасралтгүй хангадаг. • Гардан үйлдэл гүйцэтгэх мэдлэг хангалттай. • Гардан үйлдлийн ур чадвар хангалттай. • Гардан үйлдлийн үед гаргах шийдвэр, зааварчилгаа нь зөв. • Холбогдох тоног төхөөрөмж, нөөцийг зөв, зохистой ашигладаг.

НОМ ЗҮЙ

Үндсэн:

1. Б. Баярчимэг, П. Оюун-Энх, Х. Оюунхишиг "Шүдний тулгуур эд сувгийн эмчилгээний сурах бичиг" сурах бичиг 2020 он.
2. Ж. Үржинлхам, Б. Баярчимэг, М. Соёлмаа, П. Оюун-Энх, Х. Оюунхишиг "Нүүр амны эмчилгээ" сурах бичиг 2017 он. Улаанбаатар хот. ISBN-978-99973-76-42-8.

3. Cohen's "Pathway of the pulp", 2011

Нэмэлт: •

Michael G. Newman, Henry Takei, Perry R. Klokkevold. Carranza's Clinical Periodontology, 12th Edition. Elsevier

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ (жагсааж бичнэ)

- <http://www.ncbi.nlm.nih.gov/pmc/>
- <http://link.springer.com>
- <http://www.e-jds.com/>
- www.ada.org/science-research/

Вэб сайтыг суралцагч өөрөө сонгон хэрэглэнэ